

БАТЛАВ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

ДАРГА *Д.БАТ-ЭРДЭНЭ* Д.БАТ-ЭРДЭНЭ

20.04.2024 оны 05 сарын 28.

АР-УРТ БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ
“ЭРДЭНИЙ САН МАЙНИНГ ХХК”-НИЙ УУРХАЙД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ

НЭГ: ЗОРИЛГО: Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, Ашигт малтмалын хайгуулын ашиглалтын тусгай зөвшөөрөл, хамгаалалт, нөхөн сэргээх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, ажилчдын бичиг баримттай танилцах, хяналт хийх илэрсэн зөрчлийг арилгуулах.

ХОЁР: ХАМРАХ ХҮРЭЭ:

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “ЭРДЭНИЙ САН МАЙНИНГ ХХК”

ГУРАВ: ШАЛГАЛТ ХИЙХ БҮРЭЛДЭХҮҮН

ИТХ-ын дарга Д.Бат-эрдэнэ

С3Дарга Ч.Уранчимэг

Б3Дарга Ю.Туяамаа

Байгаль орчны байцаагч О.Ганбаатар

Хэсгийн цагдаа М.Батболор

ДӨРӨВ: ШАЛГАЛТ ЭХЛЭХ БОЛОН ДУУСАХ ХУГАЦАА: 2024.05.28-31

ТАВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Харьалах нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй эсэх
- Газрын тухай хуулийн 12.1.3-т заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.
- Ажилчдын бичиг баримт, визний хугацаанд хяналт тавих

ЗУРГАА: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран заасан хугацаанд тухайн "ХХК" – д хяналт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж, чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллах





АР-УРТ БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ
“ЭРДЭНИЙ САН МАЙНИНГ ХХК” – УУРХАЙД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН

2024.05.28

ТАВИН

Малчид, иргэдийн санал гомдлын мөрөөр “ЭРДЭНИЙ САН МАЙНИНГ ХХК”-д удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийллээ.

Хяналт шалгалтыг 2024.05.28-ний өдрийн 12 цаг 30 минутанд уурхай дээр очиж хийхэд уурхайд хариуцсан монгол хэлтэй хүн байхгүй байсан ба 2 гадаад иргэнтэй уулзлаа. Тэдгээр иргэд монгол хэл мэдэхгүй хятад улсын иргэд байсан ба гэр кемпд үзлэг шалгалт хийхэд нийт 6 гадаад иргэн байсан монгол хэл бүгдээрээ мэдэхгүй байв.

Уурхайг хариуцсан гүйцэтгэх захирал Барамсай нь сумын Засаг дарга Ч.Уранчимэгтэй утсаар ярилцав. Уурхайд монгол хэл мэдэх нэг ч хүн байхгүй, машин техник засахаар 4 гадаад иргэн очсон байгаа. Манайх ямар нэгэн олборолт явуулаагүй, наад хүмүүсийн бичиг баримт бүгд надад байгаа, манайх А зөвшөөрлөө авсан. Тийм учраас би мөд Адаацаг орно. Тэгээд та нартай уулзана гэж хэллээ.

Удирдамжинд орсон ажлын хэсэг гэрүүдийг шалгаж үзэхэд 3 гэр нурсан, ахиж ашиглах боломжгүй болсон, зарим гэрт бараа таваар, хоол хүнсээ хураасан байлаа.

Гэр кемпээс урагшаа жонш олборлож байж болзошгүй 2 карказан барилга дээр ирэхэд бүгд цоожтой, гадна талбайд жонш бага хэмжээгээр гаргаж ангилалт ялгалт хийсэн байдалтай байлаа.

ТАЙЛАН БИЧСЭН ИТХ-ЫН ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ

